



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2015 оны 04 сарын 01 өдөр

Дугаар 45

Мандалговь

Хөрөнгө данснаас хасах тухай

Монгол Улсын “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль”-ийн 77 дугаар зүйлийн 77.2.3, 77.3 заалт, Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2014 оны 232 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн харилцааг зохицуулах журам”-ын 2.1.7, 5.2.1 дэх заалтыг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

1. Өлзийт сумын ЗДТГ-ын үндсэн хөрөнгийн бүртгэлд бүртгэлтэй 2.500.000 /хоёр сая таван зуу/ төгрөгийн анхны өртөгтэй, 1,875,000 /нэг сая найман зуун далан таван мянга/ төгрөгийн үлдэгдэл өртөгтэй УАЗ-469 маркын автомашиныг данснаас хасах, 346,920 /гурван зуун дөчин зургаан мянга есөн зуун хорь/ төгрөгийн анхны өртөгтэй, 21,972 /хорин нэгэн мянга есөн зуун далан хоёр/ төгрөгийн үлдэгдэл өртөгтэй Пүүний байрыг буулгаж, ашиглаж болох эд хөрөнгийг эргэлтийн хөрөнгөнд бүртгэх, 12,875,480 /арван хоёр сая найман зуун далан таван мянга дөрвөн зуун наян/ төгрөгийн анхны өртөгтэй, 4,502,483 /дөрвөн сая таван зуун хоёр мянга дөрвөн зуун наян гурав/ төгрөгийн үлдэгдэл өртөгтэй хөрөнгийг хавсралтын дагуу дуудлага худалдаагаар худалдахыг зөвшөөрсүгэй.

2. Дуудлага худалдааг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж, хөрөнгө худалдсанаас орох орлогыг Төрийн сангийн хөрөнгө борлуулсны орлогын 080000962 тоот дансанд төвлөрүүлэхийг Орон нутгийн өмчийн албаны дарга П.Очирбатад үүрэг болгосугай.

3. Актлагдсан болон худалдсан эд хөрөнгийг холбогдох хууль тогтоомжийн дагуу данс бүртгэлээс хасахыг Өлзийт сумын ЗДТГ-ын дарга Б.Хорлоод даалгасугай.

ДАРГА



С.БУДЖАВ

08000962

Аймгийн ИТХТ-ийн 2015 оны 12 сарын
01 өдрийн 45-р тогтоолын хавсралт

Худалдах үндсэн хөрөнгийн жагсаалт

№	Хөрөнгийн нэр	Ашиглал танд орсон огноо	Тоо	Нэгжийн үнэ	Бүгд дүн	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл өртөг	Худалдах үнэ
1	Бага оврийн трактор	2008	1	1,910,000.0	1,910,000.0	1,910,000.0	-	300,000
2	Хүлэмж	2009	1	2,500,000.0	2,500,000.0	1,562,499.8	937,500.2	200,000
3	Портер	2010	1	2,490,000.0	2,490,000.0	1,902,083.2	587,916.8	500,000
4	Тэжээлийн агуулах	2009	1	500,000.0	500,000.0	87,963.1	412,036.9	500,000
5	Тэжээлийн агуулах	2009	1	500,000.0	500,000.0	87,963.1	412,036.9	500,000
6	Фондны саравч	2012	1	2,500,000.0	2,500,000.0	749,999.9	1,750,000.1	800,000
7	Пүүний контор	1975	1	1,143,660.0	1,143,660.0	771,970.7	371,689.3	300,000
8	Шуудайны байр	1980	1	755,580.0	755,580.0	745,086.0	10,494.0	100,000
9	Модон склад	1980	1	576,240.0	576,240.0	555,430.9	20,809.1	100,000
Нийт дүн					12,875,480.0	8,372,996.7	4,502,483.3	3,300,000